



2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ
ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Женкотур бюро” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Женкотур бюро” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 09:30 цагт цахимаар хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - а. Комданийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - б. 2021 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах
 - с. Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 - д. ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг батлах тухай
 - е. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - ф. ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 дахь өдөр буюу 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-аар баталсугай. Хавсралт №3-т заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани болон компанийн өөрийн байран дээрээс ирж танилцах боломжтой.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсрал №4-ийн дагуу баталсугай.

8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдрийн өмнөх өдөр буюу 2022 оны 04 дүгээр сарын 19-ний 11:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Ү.Тэмүүжин, хурал зохион байгуулах комиссын даргаар О.Баярцэцэг гишүүнээр Б.Мөнхтулга, П.Бат-Очир, тооллогын комиссын даргаар Л.Хүрэлсүх гишүүнээр Б.Мөнхтулга, Э.Лхагважав нарыг тус тус томилсугай.

10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан журмын дагуу удирдан зохион байгуулах ажлыг гүйцэтгэх захирал /Б.Намуун/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Ү.ТЭМҮҮЖИН/